



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/30/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Ахлах аудитор: С.Ариунбаяр
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДБЭХС	Дорнод Бүсийн Эрчим Хүчний Сүлжээ
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МЗЕГ	Мал Эмнэлгийн Ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
М.МОЛОРЧИМЭГ ТАНАА

2023.02.17 № 39
ганай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Мал, эмнэлгийн газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 96.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

D:/Bichig hereg/2023/A4 toot

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>169294121.62</u>	<u>145176244.33</u>
34	УРЬДЧИЛГАА	7200000.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	7200000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	162094121.62	145176244.33
351	Түүхий эд материал	153385219.62	125864479.33
35130	Эм боох материал	153385219.62	125864479.33
354	Хангамжийн материал	7253902.00	17656765.00
35410	Бичиг хэргийн материал	812640.00	868040.00
35420	Аж ахуйн материал	5941262.00	16203425.00
35470	Бусад хангамжийн материал	500000.00	585300.00
35600	Мал амьтад	1455000.00	1655000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>471743426.25</u>	<u>362960753.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	471743426.25	362960753.02
392	Биет хөрөнгө	326056759.57	219340753.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	86266916.00	86266916.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13762261.93	-15340289.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	231912029.67	201912029.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-152726321.77	-139719187.45
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	504125663.92	474443663.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-348156835.20	-403607205.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48252607.50	52282126.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30394621.84	-36974383.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	1850000.00	1850000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1310416.78	-1772916.82
393	Биет бус хөрөнгө	145686666.68	143620000.00
39301	Програм хангамж	3580000.00	3580000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1513333.32	-3580000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	143620000.00	143620000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>641037547.87</u>	<u>508136997.34</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>79565379.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	79565379.00
413	Өглөг	0.00	79565379.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	354029.00
4136	Бусад өглөг	0.00	79211350.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	79211350.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>641037547.87</u>	<u>428571618.34</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	641037547.87	428571618.34
512	Хуримтлагдсан үр дүн	597086304.07	384620374.54
51210	Өмнөх үеийн үр дүн	661815028.29	597086304.07
51220	Тайлант үеийн үр дүн	-64728724.22	-212465929.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43951243.80	43951243.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>641037547.87</u>	<u>508136997.34</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,170,822,919.2	2,545,491,554.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,363,564,669.2	1,229,862,134.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,363,564,669.2	1,229,862,134.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,363,564,669.2	1,229,862,134.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,000.0	1,392,300.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,363,536,669.2	1,228,469,834.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,807,258,250.0	1,315,629,420.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906,939,600.0	947,479,900.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906,939,600.0	947,479,900.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	900,318,650.0	368,149,520.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34,502,100.0	39,500,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс ... төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	865,816,550.0	328,649,520.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,175,119,051.5	2,757,957,484.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,175,119,051.5	2,757,957,484.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,146,472,572.5	2,703,177,542.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,689,714.7	458,150,794.9
210101	Үндсэн цалин	390,178,059.8	355,882,735.7
210102	Нэмэгдэл	68,887,664.3	74,824,511.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,623,990.7	25,428,430.4
210104	Урамшуулал	-	2,015,117.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,777,102.5	54,924,063.5
210201	Тэтгэврийн даатгал	44,680,402.5	42,186,928.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,774,200.0	3,527,257.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,819,300.0	3,784,453.4
210204	Ажилгүйдлийн даатгал	954,900.0	493,456.8
210205	Эрүүл мэндийн даатгал	9,548,300.0	4,931,968.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,017,878.3	24,355,174.7
210301	Гэрэл, цахилгаан	9,189,999.0	20,448,629.0
210302	Түлш, халаалт	3,586,779.3	3,716,445.7
210303	Цэвэр, бохир ус	241,100.0	190,100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	65,767,760.7	53,055,499.3
210401	Бичиг хэрэг	4,564,150.0	3,781,150.0
210402	Тээвэр, шатахуун	15,966,732.0	19,735,117.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,487,700.0	4,282,592.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	711,600.0	159,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	526,650.0	484,650.0
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	40,510,928.7	24,612,990.2
2105	Нормативт зардал	1,318,595,129.0	1,270,786,925.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,318,595,129.0	1,270,786,925.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,271,593.0	29,904,957.0
210604	Урсгал засвар	4,271,593.0	29,904,957.0
2107	Томилолт, зочны зардал	17,838,400.0	7,094,500.0
210702	Дотоод албан томилолт	17,838,400.0	7,094,500.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,132,819,855.0	690,541,335.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,127,752,380.0	681,772,365.0
210803	Даатгалын үйлчилгээ	632,655.0	360,450.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	549,820.0	326,520.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.0	231,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.0	7,740,000.0
210807	Газрын төлбөр	142,000.0	111,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,695,139.3	114,364,292.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,979,600.0	34,100.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,715,539.3	114,330,192.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,646,479.1	54,779,941.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,635,501.0	26,953,500.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,839,500.0	26,173,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	796,001.0	780,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,010,978.1	27,826,441.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,010,978.1	27,826,441.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,296,132.3)	(212,465,929.5)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1807286250.00	1317021720.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28000.00	1392300.00
120	Нийтлэг татварын бус орлого	28000.00	1392300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28000.00	1392300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28000.00	1392300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1807258250.00	1315629420.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906939600.00	947479900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906939600.00	947479900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	900318650.00	368149520.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	34502100.00	39500000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	865816550.00	328649520.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1805086250.00	1315503720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1805086250.00	1315503720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1776439770.95	1260723778.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477318159.86	458150794.89
210101	Үндсэн цалин	391696702.75	355882735.73
210102	Нэмэгдэл	70002266.42	74824511.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15619190.69	25428430.37
210104	Урамшуулал	0.00	2015117.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63998797.38	54924063.53
210201	Тэтгэврийн даатгал	44902097.38	42186928.03
210202	Тэтгэмжийн даатгал	4774200.00	3527257.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	3819300.00	3784453.35
210204	Ажилгүйдлийн даатгал	954900.00	493456.82
210205	Эрүүл мэндийн даатгал	9548300.00	4931968.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13129698.71	24001145.70
210301	Гэрэл, цахилгаан	9189999.01	20094600.00

210302	Түлш, халаалт	3698599.70	3716445.70
210303	Цэвэр, бохир ус	241100.00	190100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24283270.00	28859429.02
210401	Бичиг хэрэг	4452300.00	3781450.00
210402	Тээвэр, шатахуун	15301670.00	19735117.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3487700.00	4282592.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	711600.00	159000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	330000.00	901270.00
2105	Нормативт зардал	22233290.00	43779260.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21655690.00	43329260.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	577600.00	450000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14631000.00	29784600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9800000.00	0.00
210604	Урсгал засвар	4831000.00	29784600.00
2107	Томилолт, зочны зардал	17838400.00	7094500.00
210702	Дотоод албан томилолт	17838400.00	7094500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1142019855.00	604129985.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1129752380.00	602561015.00
210803	Даатгалын үйлчилгээ	632655.00	360450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	549820.00	326520.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143000.00	231000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10800000.00	540000.00
210807	Газрын төлбөр	142000.00	111000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	987300.00	10000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	987300.00	10000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28646479.05	54779941.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	27635501.00	26953500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26839500.00	26173500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	796001.00	780000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1010978.05	27826441.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1010978.05	27826441.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>2200000.00</u>	<u>1518000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2200000.00	1518000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2200000.00	1518000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2200000.00	1518000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2200000.00	1518000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-2200000.00</u>	<u>-1518000.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	43,951,243.80	661,815,028.29	705,766,272.09
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	43,951,243.80	661,815,028.29	705,766,272.09
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,296,132.30	-4,296,132.30
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	43,951,243.80	657,518,895.99	701,470,139.79
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	43,951,243.80	657,518,895.99	701,470,139.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	43,951,243.80	657,518,895.99	701,470,139.79
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-212,465,929.53	-212,465,929.53
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	43,951,243.80	445,052,966.46	489,004,210.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	949,479,900.0	921,049,263.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	949,479,900.0	921,049,263.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	922,519,600.0	894,095,763.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,145,700.0	458,150,794.9
210101	Үндсэн цалин	346,793,900.0	355,882,735.7
210102	Нэмэгдэл	89,143,800.0	74,824,511.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,208,000.0	25,428,430.4
210104	Урамшуулал	12,000,000.0	2,015,117.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,143,300.0	54,924,063.5
210201	Тэтгэврийн даатгал	42,197,400.0	42,186,928.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,311,500.0	3,527,257.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,049,200.0	3,784,453.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,462,300.0	493,456.8
210205	Эрүүл мэндийн даатгал	10,122,900.0	4,931,968.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,169,500.0	24,001,145.7
210301	Гэрэл, цахилгаан	20,094,600.0	20,094,600.0
210302	Түлш, халаалт	3,882,000.0	3,716,445.7
210303	Цэвэр, бохир ус	192,900.0	190,100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	20,363,400.0	20,362,929.0
210401	Бичиг хэрэг	3,586,100.0	3,781,450.0
210402	Тээвэр, шатахуун	11,392,600.0	11,238,617.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,300,100.0	4,282,592.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,500.0	159,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	914,100.0	901,270.0
2105	Нормативт зардал	18,787,800.0	18,779,260.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,336,400.0	18,329,260.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	451,400.0	450,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,831,300.0	26,802,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,518,000.0	1,518,000.0
210604	Урсгал засвар	25,313,300.0	25,284,600.0
2107	Томилолт, зочны зардал	3,146,000.0	3,146,000.0
210702	Дотоод албан томилолт	3,146,000.0	3,146,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	287,932,600.0	287,928,970.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	286,360,000.0	286,360,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	360,500.0	360,450.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	326,600.0	326,520.0

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	234,500.0	231,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.0	540,000.0
210807	Газрын төлбөр	111,000.0	111,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,960,300.0	26,953,500.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,960,300.0	26,953,500.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,173,500.0	26,173,500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	786,800.0	780,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	947,479,900.0	947,479,900.0
1320	УЛСЫНТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	947,479,900.0	947,479,900.0
122005	Улсын төсвөөс санхүүжих	947,479,900.0	947,479,900.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	368,146,015.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	368,146,015.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	368,146,015.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	8,496,500.0
210402	Тээвэр, шатахуун	-	8,496,500.0
2105	Нормативт зардал	-	25,000,000.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	25,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,500,000.0
210604	Урсгал засвар	-	4,500,000.0
2107	Томилолт, зочны зардал	-	3,948,500.0
210702	Дотоод албан томилолт	-	3,948,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	316,201,015.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	316,201,015.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,000,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,000,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	368,149,520.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	368,149,520.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	39,500,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	328,649,520.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар “Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино.” эрхэм зорилгын хүрээнд мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх, бүс, нутгийн халдварт өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 132,900.5 мянган төгрөгөөр буюу 20.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Б	/мянган төгрөгөөр/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
		1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		-	-	-
Урьдчилж гарсан зардал		7,200.0	0	-7,200.0
Бараа материал		162,094.1	145,176.2	-16,917.9
Үндсэн хөрөнгө		471,743.4	362,960.8	-108,782.6
Нийт хөрөнгө		641,037.5	508,137.0	-132,900.5
Өр төлбөр		-	79,565.4	79,565.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		641,037.5	428,571.6	-212,465.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		641,037.5	508,137.0	-132,900.5

- Урьдчилж гарсан зардал данс. Өмнөх онд Сангийн яамны төсвийн төлөвлөлттэй холбоотойгоор open.gov.mn цахим программын төлбөрийг урьдчилж гарчээ.
- Бараа материал данс 16,917.9 мянган төгрөгөөр буурсан байна. Малын гоц халдварт шүлхий, мялзан зэрэг өвчний урьдчилан сэргийлэх 36,240.0 мянган төгрөгийн вакцины үлдэгдлийг МЭЕГ-ын шийдвэрээр Дорнод аймгийн Мал эмнэлгийн газарт үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн нь нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө данс 108,782.6 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл гол нөлөө үзүүлсэн бол ТӨБЗГ-ийн шийдвэрээр 30,000.0 төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 31,200.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталж данс бүртгэлээс хассан байна;
- Богоино хугацаат өр төлбөр данс: тайлант онд УТХО-аар баригдсан ариутгалын пунктын барилга ашиглалтад орж цахилгааны төлбөрийг төлөхтэй холбоотойгоор ДБЭХС ХХК-д 354.0, хувийн мал эмнэлгүүдэд бруцеллэз өвчний вакцин тарилгын үйлчилгээний төлбөрийн дутуу санхүүжилттэй холбоотой 79,211.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 723,996.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогыг 2,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 947,479.9 мянга, үйл ажиллагааны орлого 2,000.0 мянган төгрөг батлагдсан байна. Энэ нь МЭЕГ-аас бруцеллэз, боом, галзуу гэх мэт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын санхүүжилт 274,360.0 мянган төгрөгийг үндсэн дансаар дамжуулан гаргасан нь нөлөөлж байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 947,479.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 947,479.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 1,392.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 921,049.3 мянган төгрөг буюу 97.2 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагаа	630,551.9	602,735.8	27,816.1	95.5%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	26,960.3	26,953.5	6.8	99.9%
3	82504-Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	99,107.0	99,107.0	-	100%
4	82507-Малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх	175,253.0	175,253.0	-	100%
5	82510-Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлт	17,000.0	17,000.0	-	100%
НИЙТ		948,872.2	921,049.3	27,822.9	97.0

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 95.5 хувьтай хэрэгжсэн нь батлагдсан бүтэц орон тоо дутуугаас (4 орон тоо дутуу) цалин, нэмэгдэл урамшууллын зардал 27,816.1 мянган төгрөгөөр хэмнэгдэж дээд шатны төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд МЭЕГ-аас малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын хөлс, барилгын дээврийн засварт 307,202.2 мянга, УМЭАЦТЛ-с шүлхий, цэцэг зэрэг өвчний тандалт судалгааны ажилтай холбоотойгоор 21,447.3 мянга, аймгийн ЗДТГ-аас гадна гэрэлтүүлэг, эм бэлдмэл худалдан авах, урсгал засварын ажилд зориулж 39,500.0 мянга нийт 368,149.5 мянган төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 368,146.0 мянган төгрөгийг зарцуулж 3.5 мянган төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл тээвэр шатахууны зардалд 8,496.5 мянга, эм бэлдмэл худалдан авахад 25,000.0 мянга, урьдчилан сэргийлэх тарилгын хөлсөнд 316,201.0 мянга, бусад зардалд 18,448.5 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 2,757,957.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 27,579.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 17.8-10,904.6 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: гэрэл цахилгааны зардал 10,904.6 мянга, тээвэр шатахууны зардал 4,433.4 мянга, түлш халаалтын зардал 17.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Гэрэл цахилгааны зардал: УТХО-аар баригдсан ариутгалын байр ашиглалтад орсонтой холбоотой гэрэл цахилгааны төлбөр (цахилгаанаар халдаг) нэг сард дунджаар 1,700.0-2,000.0 мянган төгрөгийн төлбөр төлж байгаа нь нөлөөлсөн.*
- *Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунджаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8³ заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар сумын Мал эмнэлгийн тасагт тэтгэвэрт гарсан албан хаагчийг гэрээгээр авч ажиллуулсан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн⁴ 22.1.6⁵, 27 дугаар зүйлийн 27.1⁶, 42 дугаар зүйлийн 42.1-т заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан тухай хуулийг баримталж ажиллах зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газарт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,440.0			
Зөвлөмж	1	-			100
Нийт дүн	2	5,440.0	2	5,440.0	100

³ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

⁴ Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага

⁵ энэ хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байх;

⁶ Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,747.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 211.5 мянган төгрөгийн зөрчил⁷ илэрч төлбөрийн акт тогтоож, 5,536.0 мянган төгрөгийн алдаа⁸ илэрснээс, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Хөлсөөр ажиллуулах гэрээтэй албан хаагчид 211.5 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна. Энэ нь Төсвийн төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁹, 41 дүгээр зүйлийн 41.2.3¹⁰ заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн захиргааны албан тушаалд тэтгэвэр тогтоолгосон иргэнтэй хөлсөөр ажиллуулах гэрээг хугацаагүйгээр байгуулж, томилсон нь Төрийн албаны тухай хуулийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн албан тухай хуульд заасны дагуу сул орон тоог нөөцөд байгаа иргэдээс нөхөх, байхгүй тохиолдолд ажлын байрыг зарлах, энэ хугацаанд түр орлон гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын 39207-тавилга, эд хогшил дансанд 1,105.3 мянган төгрөгийн усны хувцас, цонхны хөшиг, 39214-бусад үндсэн хөрөнгө дансанд 1,850.0 мянган төгрөгийн гэрлэн хаяг бүртгэж үндсэн хөрөнгийн үлдэгдлийг буруу илэрхийлсэн.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн 39207 дансанд бүртгэлтэй 1,105.3 мянган төгрөгийн аж ахуйн зориулалттай материалыг 35420 дансанд шилжүүлэн бүртгэх, 39214 дансанд бүртгэлтэй 1,850.0 мянган төгрөгийн гэрлэн хаягийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүсэлт гарган шийдвэрлүүлж данс бүртгэлээс хасах;

3. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан 2881.0 мянган төгрөгийн бараа материалыг 35420 дансанд /кабель утас, хаалга, хулдаас гэх мэт/ үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд зарцуулсан дээрх дансанд бүртгэлтэй материалыг анхан шатны баримтад үндэслэн данс бүртгэлээс хасаж, үлдэгдлийг үнэн зөв илэрхийлэх;

Илрүүлэлт: Байгууллагын дансанд бүртгэлтэй малыг зах зээлийн ханшаас багаар бүртгэж бодит үнэ цэний аргаар толилуулаагүй байна.

⁷ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁸ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

⁹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹⁰ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<i>www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээллэсэн</i>	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн албан тухай хуулийн дагуу сул орон тоог нөхөөгүй	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Нийт дүн	2	0					2	0